



**МОНГОЛ УЛСЫН
ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН
ГИШҮҮНИЙ ТОГТООЛ**

2021 оны 03 сарын 15 өдөр

Дугаар 29

Улаанбаатар хот

**Саналыг Цэцийн бага суудлын хуралдаанд
хэлэлцүүлэхээр шилжүүлэх тухай**

Нэр бүхий иргэдээс Монгол Улсын Их Хурлын 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдөр баталсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь заалт, 5 дугаар зүйлийн 5.4, 5.6 дахь хэсэг, мөн хуулийн 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, Арван есдүгээр зүйлийн 1, Гучдугаар зүйлийн 2, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийг зөрчсөн гэх агуулга бүхий мэдээлэл ирүүлснийг Үндсэн хуулийн цэцийн гишүүн Д.Солонго урьдчилан шалгаад, маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэж, нэгтгэн шалгах тухай 2021 оны 11, 12, 13, 16 дугаар тогтоол гаргасан байна.

Үндсэн хуулийн цэцийн гишүүн Б.Буяндэлгэр маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэж, нэгтгэн шалгах тухай дээрх тогтоолыг эс зөвшөөрч Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн даргад хандан санал гаргасан байна.

Дээрх саналыг Цэцийн бага суудлын хуралдаанд хэлэлцүүлэх бэлтгэл ажиллагаа хангагдсан гэж үзэж Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг удирдлага болгон **ТОГТООХ нь:**


1. Үндсэн хуулийн цэцийн гишүүний 2021 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн "Маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэх тухай" 11 дүгээр тогтоол, 2021 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн "Маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэх тухай" 12 дугаар тогтоол, мөн өдрийн "Маргаан нэгтгэн шалгах тухай" 13 дугаар тогтоол, 2021 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн "Маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэж, нэгтгэн шалгах тухай" 16 дугаар тогтоолыг эс зөвшөөрч Үндсэн хуулийн цэцийн гишүүний гаргасан саналыг Цэцийн бага суудлын хуралдаанаар хэлэлцүүлэхээр шилжүүлсүгэй.

2. Үндсэн хуулийн цэцийн бага суудлын хуралдааныг 2021 оны 3 дугаар сарын 19-ний өдрийн 10.00 цагаас Үндсэн хуулийн цэцийн Бага суудлын хуралдааны танхимд хийхээр товловсугай.

3. Хуралдааны бэлтгэл ажиллагааг хангахыг Цэцийн хуралдааны нарийн бичгийн дарга Б.Баяржаргалд даалгасугай.

ГИШҮҮН

Ш.ЦОГТОО



65

1774189